

**ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК**  
**2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/**

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй*

Тайлагнах хугацаа	2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид "Банк" эсхүл "ХХБ" гэх) УБГД: 9007001015 Үнэт цаасны код: MN00TDB05673 Утасны дугаар: 11 328227
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүү
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	50,600,927
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Л.Сайнбаяр - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ажлын албаны Гадаад харилцааны мэргэжилтэн  Хянасан: Н.Нямсүрэн - ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

1.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Хавсралт 1- Санхүүгийн нэгтгэсэн тайлан
	Орлогын тайлан	
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	
	Мөнгөн гүйлгээний тайлан	

2	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>
	Хавсралт 2

3	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>
---	---

3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	<b>Жилийн эцсийн санхүүгийн тайлан</b>		
			<b>12/31/2025</b>	<b>06/30/2026</b>
			<b>(хувь)</b>	<b>(хувь)</b>
		Хөрөнгийн өгөөж	1.38%	0.40%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	15.29%	4.30%

3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	<b>№</b>		
		<b>Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт</b>	<b>Байвал зохих</b>	<b>Банк</b>
		1	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>25% 43.44%

*Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл*

Худалдаа, хөгжлийн банк ХК (ХХБ) нь олон улсын хөрөнгийн зах зээл болон хөгжлийн санхүүжилтийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар ХХБ-ны 300 сая ам.долларын дүнтэй хаалттай бонд болон 50 сая ам.долларын ногоон, нийгмийн бонд нь Австрийн хөрөнгийн биржид амжилттай арилжаалагдаж байна. Түүнчлэн АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпораци (DFC), Европын Холбооны долоон улсын засгийн газрын хамтран байгуулсан **GuarantCo** байгууллагын баталгаанд үндэслэн БНСУ-ын Хөгжлийн Банкнаас санхүүжилтийн эх үүсвэр татах зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, гадаад эх үүсвэрийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

3.3. ХХБ нь банк, санхүүгийн салбарын өрсөлдөөн эрчимжиж, харилцагчдын цахим, шуурхай, хүртээмжтэй үйлчилгээ авах хэрэгцээ нэмэгдэж буй орчинд харилцагч төвтэй, платформ банк болох стратегийн зорилтын хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээ, дижитал суваг, мэдээллийн ил тод байдал болон тогтвортой санхүүжилтийн чиглэлээр тодорхой ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус зорилтын хүрээнд банк нь хиймэл оюун ухаанд суурилсан чатбот нэвтрүүлсэн. Энэхүү шийдэл нь харилцагчдаас социал медиа сувгаар ирүүлж буй хүсэлт, зурвасыг цаг алдалгүй хүлээн авах, шаардлагатай мэдээллээр хангах, холбогдох ажилтанд хуваарилах боломжийг бүрдүүлж, харилцагчийн үйлчилгээний шуурхай байдал, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн.

Мөн банк олон улсын хөрөнгийн зах зээлийн жишиг шаардлага, International Investor Relations standards-д нийцсэн мэдээллийн нэгдсэн вебсайтыг хөгжүүлэн нэвтрүүлсэн. Ингэснээр хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагч болон олон нийт банкны мэдээллийг илүү ойлгомжтой, хүртээмжтэй, нэг эх сурвалжаас авах боломж бүрдэж, банкны ил тод байдал, засаглал, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой болсон.

Иргэдийн хэрэгцээнд нийцсэн Happy Family-Happy Future карт, хадгаламж, GPS төхөөрөмжийг багтаасан багц бүтээгдэхүүнийг санал болгож, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. Биет сувгийн хүртээмжийг өргөжүүлэхээр “Энканто Цэнтро лайт тооцооны касс”-ыг шинээр нээсэн. Жижиг дунд бизнес, байгууллагын хувьд Германы Олон Улсын Хамтын ажиллагааны Нийгэмлэг-тэй хамтран Монгол Улс дахь Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, тогтвортой санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах “SFME” төслийн хүрээнд 2026 оны “Чадавхжуулах хөтөлбөр”-г эхлүүлсэн

Цаашид банк нь гадаад, дотоод орчны өөрчлөлтөд нийцүүлэн харилцагчийн үйлчилгээний чанар, бүтээгдэхүүн үйлчилгээний өрсөлдөх чадвар, дижитал сувгийн хүртээмж, мэдээллийн ил тод байдал, хөрөнгө оруулагчидтай харилцах тогтолцоо болон тогтвортой санхүүжилтийн чиглэлээ үргэлжлүүлэн бэхжүүлэхээр ажиллаж байна. Эдгээр арга хэмжээ нь хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, харилцагчдад орчин үеийн, хүртээмжтэй, найдвартай банкны үйлчилгээ хүргэх, банкны дунд болон урт хугацааны өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэж байна.

3.4. *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого*

Тэнцлийн гадуурх данс	MNT'000
Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр)	1,858,298,913

4 *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/*

Банкны ТУЗ-өөс 2026 оны эхний хагас жилд нийт 8 тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг олгосон ба тухайн ТУЗ-ийн тогтоолуудыг тухай бүрт нь МХБ-ийн болон өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн болно.

Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу нь холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив, бусад үүрэг, ажил, үйлчилгээний мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэлдэг.

2026 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар (сая төгрөгөөр)

Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)	Активын хэлбэр	Үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1. Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)			
1.1. Банкны хувьцаа эзэмшигч	Зээл, Авлага	-	0.00%
1.2. Банкны эрх бүхий албан тушаалтан	Зээл	778.65	0.05%
1.3. Банкны бусад холбогдох этгээд	Авлага	79,742.39	4.81%
2. Банкны холбогдох нийт этгээд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)			
2.1. Банкны хувьцаа эзэмшигчид	Зээл, Авлага	-	0.00%
2.2. Банкны эрх бүхий албан тушаалтанууд	Зээл, Авлага	4,649.47	0.28%
2.3. Банкны бусад холбогдох этгээд	Зээл, Бусад актив	267,628.28	16.14%

\*Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад заасны дагуу Банкны холбогдох этгээдийг тодорхойлдог.

Банк нь Тайлант хугацаанд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт тодорхойлсон их хэмжэний хэлцэл байгуулаагүй байна.

*Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл*

5 Худалдаа, хөгжлийн банк ("ХХБ") нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг дунд хугацааны Бизнес төлөвлөгөөний зорилтоо хэрэгжүүлэх ажлын хүрээнд банкны үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголтод зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд "Ногоон банк" болох урт хугацааны тэргүүлэх дэд стратеги чиглэлийн хүрээнд ХХБ-ны "Тогтвортой санхүүжилтийн хүрээ" баримт бичигт тусгагдсан ногоон болон нийгмийн зээлийн ангиллуудад уялдуулан санхүүжилт олгосон. Анхдагч зах зээлийн арилжаанд нийт 2'528 хөрөнгө оруулагчдаас 105.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий захиалга хүлээн авч, татан төвлөрүүлэх зорилтот дүн болох 83.5 тэрбум төгрөгийн захиалга 126.4% гүйцэтгэлтэйгээр хаагдсан. Банк нь активын зохистой бүтцийг бий болгох, иргэд болон жижиг, дунд бизнесийн зах зээлд тэлэлт хийх стратеги төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг бизнесийн сегментүүдийн ногоон болон нийгмийн зээлийн санхүүжилтэд төлөвлөсний дагуу 2024 оны 3-р улиралд амжилттайгаар бүрэн гүйцэтгэж дуусгасан байна


*Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*

6 Хавсралт 3

*Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл*

7 Хавсралт 3

Үнэт цаас гаргагчийн бүтэц (толгой, охин, хараат, зэргэлдээ компаниуд, тэдгээрийн хувь эзэмшлийн талаар), холбоотой талуудын санхүүгийн гүйлгээний талаарх мэдээлэл;



Холбогдох этгээдийн мэдээлэл Худалдаа, хөгжлийн банкны Аудитлагдсан санхүүгийн тайланд тусгагдсан.

2026 оны эхний хагас жилийн байдлаар холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ 610,771,864.5 мянган төгрөг байсан.

Үнэт цаас гаргагч нь (Банк, Даатгал, Банк бус санхүүгийн байгууллага, болон Үнэт цаасны компани) төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Банк
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>9%	14.23%
2	Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>13%	14.23%
3	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (Нэгж валютаар)	<+/-15%	-2.19%
4	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (Нэгж валютаар)	<+/-30%	-6.49%

Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах, компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэх, компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болох нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, энэхүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл

Тайлант хугацаанд дээрх нөхцөл байдал үүсээгүй байна.

Тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны тоо, ширхэг, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн, үнэт цаасаар урамшуулал олгосон талаарх мэдээлэл

Тайлант хугаанд хувьцаа эзэмшлийн бүтэцд өөрчлөлт ороогүй байна.



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: О.ОРХОН

Албан тушаал: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэж, хургуулсан этгээдийн гарын үсэг, огноо 2026/07/09

Овог, нэр: Н.НЯМСҮРЭН

Албан тушаал: ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Гарын үсэг:

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ**  
**АУДИТЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТ**

2026 оны 07 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн багц материалын дагуу үнэн зөв тайлагнагдсан болохыг баталгаажуулан Худалдаа хөгжлийн банк ХК-иас танилцуулсан тус банкны 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, үзүүлэлтүүд, санхүүгийн төсвийн гүйцэтгэлтэй Аудитын хорооны хурлаар танилцлаа.

Худалдаа хөгжлийн банк нь 2026 оны эхний хагас жилд 17.7 их наяд төгрөгийн активтай, 71.2 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай, Монголбанкнаас тогтоосон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажилласан байна. Банк нь 2026 оны эхний хагасд ТУЗ-өөс өгсөн актив, пассив, орлогын төсөв, төлөвлөгөөг биелүүлсэн нь сайн үр дүн гэж үзлээ. Харин чанаргүй активын төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байгааг тэмдэглэж, 2026 оны 2-р хагаст чанаргүй активын төлүүлэлтэд онцгой анхаарч ажиллахыг зөвлөж байна.

АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА




Ж.БОЛОРМАА

АУДИТЫН ХОРООНЫ ГИШҮҮН



Д.ГАНТӨГС

АУДИТЫН ХОРООНЫ ГИШҮҮН



Д.ОТГОНБИЛЭГ

Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк  
Регистр: 2635534

**САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2025.12.31)	Эцсийн үлдэгдэл (2026.06.30)
1	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1.	<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>3,130,545,021</b>	<b>3,208,703,267</b>
1.1.1	Бэлэн мөнгө	78,685,103	80,730,871
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө	1,231,089,462	1,208,158,269
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	1,820,175,329	1,919,107,761
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	595,127	706,366
1.2	<b>Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө</b>	<b>4,622,059,198</b>	<b>3,491,837,834</b>
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	4,622,372,134	3,492,150,770
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-	-
1.2.3	Бусад хөрөнгө	-	-
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-	-
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	(312,936)	(312,936)
1.3	<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>1,231,647,017</b>	<b>1,606,713,740</b>
1.3.1	Арилжааны үнэт цаас	-	-
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	1,189,691,963	1,549,026,615
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	9,665,545	17,028,932
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	-	-
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	1,769,992	1,769,992
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	-	-
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	30,552,896	38,921,580
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	(33,379)	(33,379)
1.4	<b>Зээл (цэвэр дүнгээр)</b>	<b>7,919,104,322</b>	<b>8,229,948,483</b>
1.4.1	Хэвийн зээл	7,534,221,952	7,893,299,905
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	289,336,647	210,693,142
1.4.3	Хэвийн бус зээл	30,816,068	41,022,692
1.4.4	Эргэлзээтэй зээл	42,528,453	37,401,397
1.4.5	Муу зээл	252,497,026	345,794,862
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(22,780,064)	(29,488,921)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	172,791,714	151,581,786
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(380,307,473)	(420,356,380)
1.5	<b>Дериватив санхүүгийн хөрөнгө</b>	<b>86,412,028</b>	<b>91,219,416</b>
1.6	<b>Бусад санхүүгийн хөрөнгө</b>	<b>67,187,369</b>	<b>140,864,125</b>
1.6.1	Бусад санхүүгийн хөрөнгө	53,863,780	125,122,272
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	10,551,010	10,956,850
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	-
1.6.4	Бусад	2,772,579	4,785,003
1.7	<b>Бусад санхүүгийн бус хөрөнгө</b>	<b>473,336,912</b>	<b>174,831,327</b>
1.7.1	Бусад тооцоо	51,111,916	73,479,144
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	5,606,155	3,966,255
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	161,016,258	21,052,971
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	254,433,955	75,164,907
1.7.5	Татварын авлага	1,167,988	1,167,988
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.7.7	Бусад	640	62
1.8	<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>574,699,475</b>	<b>606,106,109</b>
1.9	<b>Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө</b>	<b>100,192,970</b>	<b>64,766,180</b>
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	8,936,905	24,510,155
1.11	Биет бус хөрөнгө	49,905,429	63,842,539
1.12	Нийт хөрөнгийн дүн	18,264,026,646	17,703,343,175
2	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1	<b>Харилцах</b>	<b>3,894,221,594</b>	<b>4,096,674,715</b>
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	3,894,221,594	4,096,674,715
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	0	-
2.2	<b>Хадгаламж</b>	<b>7,234,500,339</b>	<b>7,050,237,199</b>
2.2.1	Хугацаагүй хадгаламж	752,506,300	794,698,628
2.2.2	Хугацаатай хадгаламж	6,284,235,497	6,049,609,994
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	1,142,005	50,000
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	196,616,537	205,878,577

2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	3,847,769,691	3,155,558,677
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	1,206,997,927	931,410,039
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	2,628,287,705	2,213,033,557
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(4,299,285)	(3,463,864)
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	16,783,344	14,578,945
2.4	Бусад эх үүсвэр	1,316,964,551	1,483,327,562
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	-	-
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	996,456,798	993,247,485
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	240,257,043	258,009,427
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (repo)	-	139,724,379
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	-	-
2.4.6	Бусад	75,788,791	87,824,372
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-	-
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	4,461,918	4,521,899
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	92,386,360	61,547,883
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	90,465,018	175,246,525
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	63,619,754	22,861,038
2.8	Хоёрдогч өглөг	-	-
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
2.10	Нийт өр төлбөрийн дүн	16,539,927,305	16,045,453,599
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	-	-
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	340,852,905	340,852,904
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	-	-
3.1.2	Энгийн хувьцаа	340,852,905	340,852,904
3.2	Нэмж төлөгдсөн капитал	64,069,779	64,069,779
3.3	Халаасны хувьцаа	-	-
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	143,093,248	143,093,248
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,021,846,904	1,058,068,473
3.6	Бусад өөрийн хөрөнгө	154,236,504	51,805,172
3.6.1	Хувьцааны опцион	-	-
3.6.2	Нөөцийн сан	494,516	494,516
3.6.3	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	100,110,188	-
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	-	-
3.6.6	Хувьцаанд хөрвөх үнэт цаас (өөрийн хөрөнгө)	-	-
3.6.7	Хувьцаанд хөрвөх эх үүсвэр (өөрийн хөрөнгө)	-	-
3.6.8	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан	-	-
3.6.9	Хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний сан	-	-
3.6.10	Бусад	53,631,800	51,310,656
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	1,724,099,341	1,657,889,576
4	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	18,264,026,646	17,703,343,175

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

СУХГ-ЫН ЗАХИРАЛ

САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ



О.ОРХОН

Д.ЭНХТУЯА

Ц.ДЭЛГЭРМАА

Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк  
Регистр: 2635534

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	/Мянган төгрөг/	
		Эхний үлдэгдэл (2025.12.31)	Эцсийн үлдэгдэл (2026.06.30)
1	<b>Хүүгийн орлого</b>	<b>-1,435,726,251</b>	<b>802,360,753</b>
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	16,021,069	7,436,908
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	33,959,615	18,157,259
1.3	Үнэт цаасны	249,672,212	150,578,610
1.4	Зээлийн	1,095,290,865	598,455,527
1.5	Бусад хүүгийн орлого	40,782,490	27,732,449
2	<b>Хүүгийн зардал</b>	<b>1,008,587,568</b>	<b>562,563,522</b>
2.1	Харилцахад төлсөн хүү	46,050,417	28,622,598
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	682,328,128	361,533,078
2.3	Зээлийн хүүгийн зардал	67,679,628	36,007,243
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	212,266,127	134,687,284
2.5	Бусад хүүгийн зардал	263,269	1,713,319
3	<b>ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО(1-2)</b>	<b>427,138,682</b>	<b>239,797,231</b>
4	<b>Эрсдэлийн сангийн зардал</b>	<b>111,180,051</b>	<b>155,678,104</b>
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	0	0
4.2	Үнэт цаасны	0	0
4.3	Зээлийн	111,180,051	155,678,104
5	<b>Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]</b>	<b>315,958,631</b>	<b>84,119,127</b>
6	<b>Бусад орлого</b>	<b>352,899,791</b>	<b>224,587,024</b>
6.1	<b>Хүүгийн бус орлого</b>	<b>327,958,812</b>	<b>223,576,771</b>
6.1.1	Арилжааны орлого	52,484,388	19,211,031
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	22,731,339	29,596,737
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	142,793,159	86,758,135
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	109,949,927	88,010,868
6.2	Бусад орлого, олз	24,940,979	1,010,253
7	<b>Бусад зардал</b>	<b>429,412,526</b>	<b>237,442,934</b>
7.1	<b>Хүүгийн бус зардал</b>	<b>419,068,474</b>	<b>236,776,919</b>
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	23,611,284	31,508,535
7.1.2	Арилжааны зардал	5,508,379	21,591,032
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	32,482,088	7,780,682
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	67,516,766	32,479,215
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	289,949,957	143,417,455
7.2	Бусад зардал, гарз	10,344,052	666,015
8	<b>Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)</b>	<b>239,445,896</b>	<b>71,263,218</b>
9	Орлогын татварын зардал	38,895,925	25,808
10	<b>Татварын дараах ашиг, алдагдал (8-9)</b>	<b>200,549,971</b>	<b>71,237,410</b>
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	0	0
12	<b>Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)</b>	<b>200,549,971</b>	<b>71,237,410</b>
13	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>8,765,637</b>	<b>-2,321,144</b>
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	0	0
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	8,765,637	-2,321,144
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт	0	0
13.4	Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт	0	0
13.5	Бусад	0	0
14	<b>Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)</b>	<b>209,315,608</b>	<b>68,916,266</b>

№	Тэнцлийн гадуурх данс	/Мянган төгрөг/
1	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамраах үүрэг (цэвэр дүнгээр)	1,858,298,913

ГҮЙЦЭГТЭХ ЗАХИРАЛ

СУХГ-ЫН ЗАХИРАЛ

САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ

О ОРХОН

Д ЭНХТУЯА

Ц ДЭЛГЭРМАА



Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк  
Регистр: 2635534

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2025.12.31)	Эцсийн үлдэгдэл (2026.06.30)
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>***</b>	<b>***</b>
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	239,445,897	71,263,218
1.2	<b>Орлого, зардлын тохируулга</b>	<b>(364,756,292)</b>	<b>(142,947,575)</b>
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	44,749,308	94,687,161
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	17,633,083	2,162,496
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	0	0
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(1,435,726,251)	(802,360,753)
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	1,008,587,568	562,563,522
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	0	0
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	0	0
1.3	<b>Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга</b>	<b>(1,149,282,145)</b>	<b>93,036,448</b>
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(1,865,553,218)	1,129,940,454
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	0	0
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	(1,846,166,036)	(483,435,974)
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	60,281,166	(10,203,846)
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(121,019,392)	107,205,566
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	1,431,589,522	8,927,941
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	1,187,049,831	(688,746,884)
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	29,961,614	41,167,986
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	(25,425,633)	(11,818,795)
1.4	<b>Бусад тохируулга</b>	<b>379,831,934</b>	<b>259,730,288</b>
1.4.1	Авсан хүү (+)	1,386,355,104	815,201,997
1.4.2	Төлсөн хүү (-)	(967,627,244)	(555,445,901)
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	(38,895,926)	(25,808)
1.4.4	Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	0	0
1.4.5		0	0
1.5	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(894,760,607)</b>	<b>281,082,380</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>***</b>	<b>0</b>
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,979,769,589</b>	<b>2,769,180,885</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	48,332,758	53,186,471
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	1,802,813	112,599
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого	0	84,802,081
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого	5,031,979	0
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0	0
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	2,664,279,113	2,612,908,788
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	434,084	9,208,291

2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг	0	0
2.1.10	Бусад мөнгөн орлого	259,888,841	8,962,655
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(2,910,044,096)</b>	<b>(3,151,842,751)</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	62,199,313	74,519,932
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,511,559	14,792,768
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	43,433,296	49,375,292
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	1,605,748	(0)
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	2,647,637,800	2,960,396,453
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	6,164,192	28,222,400
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.9	Бусад мөнгөн зарлага	143,492,189	24,535,905
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>69,725,493</b>	<b>(382,661,866)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>***</b>	<b>0</b>
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>6,396,878,276</b>	<b>5,515,940,484</b>
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	4,377,510,420	4,841,109,602
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	0	0
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0	0
3.1.4	Төрөл бүрийн хандив	0	0
3.1.5	Бусад	2,019,367,856	674,830,881
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(6,013,554,895)</b>	<b>(5,336,202,752)</b>
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	4,040,509,616	4,674,806,572
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн	0	0
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0	0
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	0	0
3.2.5	Төлсөн ногдол ашиг	101,201,854	35,015,841
3.2.6	Бусад	1,871,843,424	626,380,339
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>383,323,381</b>	<b>179,737,731</b>
4	Валютын ханшийн зөрүү	0	0
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(441,711,732)</b>	<b>78,158,246</b>
6	<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,572,256,753</b>	<b>3,130,545,021</b>
7	<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,130,545,021</b>	<b>3,208,703,267</b>

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

О.ОРХОН

СУХГ-ЫН ЗАХИРАЛ

Д.ЭНХТУЯА

САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ

Ц.ДЭЛГЭРМАА



Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк  
 Регистр: 2635534  
 ӨМЧИЙН ӨӨРЧӨЛТИЙН ТАЙЛАН

/Милан төгрөг/

№	Түүрэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дэвн үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт Дүн
	2024 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	340,852,905	64,069,779	0	143,364,654	174,759,391	892,938,857	1,616,985,687
1	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0	0	0	0
2	Залруулсан үлдэгдэл	340,852,905	64,069,779	0	143,364,654	174,759,391	892,938,857	1,616,985,687
3	Тайлант үеийн црээр ашиг, алдагдал	0	0	0	0	0	200,549,971	200,549,971
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	8,785,637	0	8,785,637
5	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0	-29,288,524	0	-29,288,524
6	Хуваарилсан мөнгөд ашиг	0	0	0	0	0	-101,201,854	-101,201,854
7	Дэвн үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	-271,406	0	271,406	0
	2025 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	340,852,905	64,069,779	0	143,093,248	154,236,504	1,021,846,904	1,724,099,341
1	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0	0	0	0
2	Залруулсан үлдэгдэл	340,852,905	64,069,779	0	143,093,248	154,236,504	1,021,846,904	1,724,099,341
3	Тайлант үеийн црээр ашиг, алдагдал	0	0	0	0	0	71,237,410	71,237,410
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	-2,321,144	0	-2,321,144
5	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0	-100,110,188	0	-100,110,188
6	Хуваарилсан мөнгөд ашиг	0	0	0	0	0	-35,015,841	-35,015,841
7	Дэвн үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0	0	0
	2026 оны 06-р сарын 30-ны өдрийн үлдэгдэл	340,852,905	64,069,779	0	143,093,248	51,805,172	1,058,068,473	1,657,889,577

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

СУХГ-ЫН ЗАХИРАЛ

САНХҮҮГИЙН ШИНЖЭЭН

О.ОРХО

Д.ЭНХТУВА

Ц.ДЭЛГЭРМАА




## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “ХХБ” гэх) нь Компанийн засаглалын чиглэлээрх бодлого, дүрэм, журам, заавруудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон засаглалын үнэлгээг оновчтой, бодитоор гаргаж, хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд үнэ цэн бүтээхэд дэмжлэг үзүүлэх, дотоодын төдийгүй олон улсын сайн туршлагыг нутагшуулан ТУЗ болон банкны бүхий л нэгжид хүрч, банкны стратеги төлөвлөгөө, байгууллагын бүтэц, бодлогыг тодорхойлон, оролцогч талуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдол өгч ажилладаг.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

ХХБ нь нээлттэй хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг Банкны эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. ХХБ нь хувьцаа эзэмшигчдэдээ хүртээмжтэй, цаг үеийн дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээг үзүүлэхийг зорьдог бөгөөд тус боллогын хүрээнд 2026 оны 4 дүгээр 29-ний өдөр ээлжит хурлаа цахим байдлаар амжилттай зохион байгуулсан.



НИЙТ ГАРГАСАН ХУВЬЦААНЫ  
ТОО

**50,600,967**


Хувьцаа эзэмшигчдийг эрх тэгш байдлаар хангах үүднээс Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөрийг ТУЗ-өөр баталсан төдийгүй ХХБ ХК-ийн дүрэмд ХЭ-ийн бүрэн эрхийг тусгасан нь эзэмшлийн хэмжээнээс үл хамааран эрх тэгш, ил тод нээлттэй мэдээллийг авах нөхцөлөөр хангагдах боломжийг ханган ажиллаж байна.

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

ХХБ ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 14 тоот тогтоолоор Банкны 2025 оны цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчидийн нэгж энгийн хувьцаанд 692.00 төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тараасан.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Банкны эрх барих дээд нэгж нь Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) байна.



ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдал, хүйсийн тэнцвэр зэргийг зохистойгоор хангасан гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр бүтээлч, үр дүнтэй бүтэцтэй байхын зорьж ажилладаг.

<p><b>ТУЗ-ийн дарга</b> Рандолф <b>КОПНА</b></p> <p><b>ТУЗ-ийн дэргэдэх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн</li> <li>- Тогтвортой хөгжлийн хорооны дарга</li> </ul> <p><i>*ХХБ-ны хувьцаа эзэмшдэггүй.</i></p>	<p><b>ТУЗ-ийн гишүүн</b> Дагмид <b>ЯНЖМАА</b></p> <p><b>ТУЗ-ийн дэргэдэх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүн</li> </ul> <p><i>*ХХБ-ны хувьцаа эзэмшдэггүй.</i></p>
<p><b>ТУЗ-ийн гишүүн</b> Должин <b>ЭРДЭНЭБИЛЭГ</b></p> <p><i>*ХХБ-д шууд хувьцаа эзэмшдэггүй</i></p>	<p><b>ТУЗ-ийн гишүүн</b> Дамбийжав <b>ХҮРЭЛБААТАР</b></p> <p><i>*ХХБ-ны хувьцаа эзэмшдэггүй.</i></p>
<p><b>ТУЗ-ийн гишүүн</b> Авгаан <b>ЭНХМЭНД</b></p> <p><i>*ХХБ-ны хувьцаа эзэмшдэггүй.</i></p>	<p><b>ТУЗ-ийн гишүүн</b> Дэмчигжав <b>ОТГОНБИЛЭГ</b></p> <p><b>ТУЗ-ийн дэргэдэх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Аудитын хорооны гишүүн</li> </ul> <p><i>*ХХБ-ны жижиц хувьцаа эзэмшигч бөгөөд 0.00% эзэмшдэг.</i></p>
<p><b>ТУЗ-ийн хараат бус гишүүн</b> Жалбаа <b>БОЛОРМАА</b></p> <p><b>ТУЗ-ийн дэргэдэх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Аудитын хорооны дарга</li> <li>- Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүн</li> </ul> <p><i>*ХХБ-ны хувьцаа эзэмшдэггүй.</i></p>	<p><b>ТУЗ-ийн хараат бус гишүүн</b> Лувсан <b>НЯМСҮРЭН</b></p> <p><b>ТУЗ-ийн дэргэдэх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны дарга</li> <li>- Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн</li> </ul> <p><i>*ХХБ-ны хувьцаа эзэмшдэггүй.</i></p>
<p><b>ТУЗ-ийн хараат бус гишүүн</b> Дамдин <b>ГАНТӨГС</b></p> <p><b>ТУЗ-ийн дэргэдэх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрсдэлийн удирдлагын хорооны дарга</li> <li>- Аудитын хорооны гишүүн</li> </ul> <p><i>*ХХБ-ны хувьцаа эзэмшдэггүй.</i></p>	<p><b>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга</b> Навааншарав <b>НЯМСҮРЭН</b></p> <p><i>*ХХБ-ны хувьцаа эзэмшдэггүй.</i></p>

## Гүйцэтгэх удирдлага

ХХБ ХК-ийн дүрмэнд Банкны гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэхээр заасан бөгөөд ноён О.Орхон 2016 оны 1 сараас тус банкны Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. ТУЗ-ийн гишүүдээс гадна дараах албан тушаалтнуудыг Банкны эрх бүхий албан тушаалтан байхаар дүрмэнд заасан байдаг.

№	Албан тушаал	Нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо, ширхэг
1	Гүйцэтгэх захирал	О.Орхон	290
2	Ерөнхийлөгч		
3	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч	А.Энхмэнд	-
4	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч	О.Банзрагч	-
5	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч	Дэ Юүн Мартэйн Кристофэл	-
6	Дотоод аудитын газрын захирал	Ч.Лхагвасүрэн	-
7	Санхүүгийн, удирдлага, хяналтын газрын захирал	Д.Энхтуяа	-

## Ил тод байдал

- Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр ХХБ-ны албан ёсны [investor.tdbm.mn](http://investor.tdbm.mn) платформуор буюу цахимаар зохион байгуулагдаж, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 91.89 хувийн ирцтэй оролцсон байна.

Дараах асуудлуудыг хувьцаа эзэмшигчдэд танилцууллаа. Үүнд:

- Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
- Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр.

Хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн санал хураалтаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж баталсан.

- Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
- Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;
- Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай.

- Тайлант хугацаанд дараах тайлангуудыг гаргасан. Үүнд:
  - Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журмын дагуу зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн тайлан;
  - Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекст заасны дагуу ХХБ-ны 2025 оны Засаглалын хэрэгжилтийн тайлан;
  - Байгаль орчин, нийгэм засаглалын тайлан;

- 2025 оны үйл ажиллагааны тайлан;
  - 2025 оны санхүүгийн аудитлагдсан тайлан;
  - 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан;
  - 2025 оны ТУЗ-ийн дэргэдэх хороодуудын ажлын тайлан;
  - ХХБ ХК-аас 2025 онд бусад оролцогч талуудтай хамтран ажилласан талаар тайлан;
  - ТУЗ-ийн хараат бус гишүүдийн улирал тутмын ажлын тайлан;
  - ТУЗ, түүний дэргэдэх хороод болон ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээ;
  - Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн сар бүрийн тайлан;
  - Банкны 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.
- Тайлант хугацаанд ТУЗ 16 удаагийн хурлаар нийт 54 тогтоол гаргасан. Үүнээс дараах журам, заавруудад эргэн хяналт хийж, шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулан засаглалын үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг авч ажилласан байна.
- “ХХБ-ны сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам”-ын нэмэлт өөрчлөлт оруулсан;
  - “ХХБ-ны залилангийн эсрэг бодлого” шинээр баталсан;
  - ТУЗ-ийн дэргэдэх “Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулсан;
  - “ХХБ-ны зээлийн бодлого”-ыг шинээр баталсан;
  - ТУЗ-ийн дэргэдэх “Аудитын хорооны дүрэм”-ийг шинэчлэн баталсан;
  - ХХБ-ны “Дотоод аудитын бодлого”-ыг шинэчлэн баталсан;
  - ХХБ-ны “Дотоод аудитын газрын журам”-ыг шинэчлэн баталсан;
  - ХХБ-ны “Аудиторын ёс зүй, мэргэжлийн байдлын дүрэм” -ийг шинэчлэн баталсан;
  - ТУЗ-ийн дэргэдэх “Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны журам”-ыг шинэчлэн баталсан.

Нээлттэй хувьцаат компанийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох заавар журмуудын дагуу хугацаат тайлан мэдээг тухай бүр хүргэж, хувьцааны үнэ ханшид нөлөөлөх, удирдлагын өөрчлөлт, сонирхлын зөрчилтэй хэлцэл зэрэг мэдээллүүдийн өөрийн албан ёсны болон МХБ-ийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.